



ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ТӨСВИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор

Т.Майцэцэг

Утас: 70273463 99018619

И-Мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн БОАЖГазрын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд / ТӨВ-2015/133/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн БОАЖГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн БОАЖГазрын 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 25-наас 2015 оны 03 дүгээр сарын 28-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн БОАЖГазар нь 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 02 дугаар сарын 22-нд ТАБ-т ирүүлсэн ба Санхүү хяналт аудитын албанаас 2013-2014 оны санхүүгийн тайланд баримтын шалгалт хийгдсэн.

Төрийн аудитын байгууллага аудитыг Санхүү хяналт аудитын албанаас хийгдсэн хяналт шалгалтын материалд тулгуурлан 2015 оны 03 дүгээр сарын 28-наас 2015 оны 03 дүгээр сарын 29-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 02 дугаар сарын 31 -нд Төв аймгийн БОАЖГазрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, ТБОНӨТХууль, НББ-ийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгөд элэгдэл тооцох тухай” журмыг 2014 оны 297 дугаар тогтоолоор хүчингүй болгосон байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15.1.1-д байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах гэж заасны дагуу тухайн байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 53.1-д Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Төв аймгийн БОАЖГазрын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталж Төв аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, үйл ажиллагаатай холбогдсон хуулиуд бүрэн хэрэгжиж, Төсвийн тухай 16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн БОАЖГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс БОАЖГазрын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 10 горим сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын даргын тушаалаар баталж боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль болон сангийн сайдын тушаалаар нягтлан бодох бүртгэлийн дансны зааварт орсон өөрчлөлтийн дагуу шинэчлэгдээгүй байна. Бүртгэлийн асcolous програм ашигладаг байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн БОАЖГазрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналттай танилцахад Дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг 10 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр төлөвлөж хэрэгжилтийг тооцон ажилласан боловч санхүүгийн механизмыг хянадаггүй байна. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу БОАЖГазрын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2014 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 372631.5 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 15380.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 366987.2 мянган төгрөг зарцуулахаар батлагдсан ба 5644.3 мянган төгрөгийг нэмж санхүүжигдсэн, гүйцэтгэлээр 374866.5 мянган төгрөгийг зарцуулж тайлагнасан байна. Нэмэлт санхүүжилтээр 15120.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 10 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн БОАЖГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Үнэт цаасны маягтын үнэ 2134.4 мянган төгрөгийг БОНХЯамны БХСангийн дансанд шилжүүлсэн гүйлгээг бууруулах бичилт хийсэн нь Засгийн газрын 2012 оны 205-р тогтоол ТСанийн үйл ажиллагааны журам 7.11-д Тухайн байгууллагын данснаас дараах тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө 7.11.3, 7.11.4 –д заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна

Шийдвэрлэсэн: Үнэт цаасны маягтын үнийг тооцооны дансаар бүртгэж тайлагнах талаар албан шаардлага бичив.

2. Батлагдсан төсвөөр Цалингийн сан нийт 267447.9 мянган төгрөг зарцуулахаас, гүйцэтгэлээр нийт 276745.4 мянган төгрөг зарцуулж батлагдсан төлөвлөгөөг 9297.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. Хэтэрсэн цалингийн 2609.7 мянган төгрөгийг харуул хамгаалалтын хөлснөөс, 3120.0 мянган төгрөгийг ус ашиглах дүгнэлт гаргасан үйлчилгээний төлбөрөөс олгосон байна. Төсвийн тухай хуулийн 16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 16.5.3-д батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох гэж заасныг хэрэгжүүлж батлагдсан орон тоогоор ажиллах зөвлөмж өгөв.

3. Өглөгийн тайланд эхний үлдэгдлийг хасах 32.3 мянган төгрөгөөр, эцсийн үлдэгдлийг хасах 53.9 мянган төгрөгөөр тайлагнасан нь санхүүгийн байдлын тайланд нөлөөлж зөрүү үүссэн

Шийдвэрлэсэн: Алдааг аудитын явцад залруулсан

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Төв аймгийн БОАЖГазрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын даргын тушаалаар баталж мөрдөж байгаа ч бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль болон сангийн сайдын тушаалаар нягтлан бодох бүртгэлийн дансны зааварт орсон өөрчлөлтийн дагуу шинэчлэгдээгүй байна.

Шийдвэрлэсэн: Байгууллагынхаа НББ-ийн бодлогын баримт бичгийг шинэчлэн өөрчлөлт оруулах зөвлөмж өгөв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад өглөгийн болон байдлын тайланд хасах тэмдэгтэй тайлагнасан 53.9 мянган төгрөгийг залруулсан.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох хөрөнгийн тооллого хийж буйг завсрын аудитаар нөхөн шалгахгаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн БОАЖГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 11518.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 53.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2134.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага бичиж, 9297.5 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх аудитаас өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн хариуг Төв аймгийн Аудитын газарт хүргүүлсэн ба 2000.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт бичигдсэнийг бүрэн барагдуулсан байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Төв аймгийн БОАЖГазрын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ,

өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ

2015 оны 03 сарын 31